

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН
(2024 оны хоёрдугаар улирал)

2024 оны 07 дугаар сарын 03

Улаанбаатар хот

Шилэн дансны тухай хуульд заасны дагуу (www.shilendans.gov.mn) цахим хуудсанд Гадаадын иргэн, харьяатын газрын төв болон боомт, орон нутаг дахь газар, хэлтсийн 2024 оны хоёрдугаар улиралд байршуулсан мэдээллийн тоон үзүүлэлтийг нэгтгэн танилцуулж байна.

Нэг. Мэдээлэл байршуулж байгаа байгууллагын статистик үзүүлэлтийн талаар

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасны дагуу 2024 оны хоёрдугаар улирлын байдлаар шилэн дансны нэгдсэн цахим системд бүртгэлтэй мэдээлэл байршуулах, тайлан илгээх үүрэг бүхий Гадаадын иргэн, харьяатын газрын төсвийн төвлөрүүлэн захирагч, шууд захирагч зэрэг нийт хууль хэрэгжүүлэгч 8 байгууллага нь 3 ангиллын 29 төрлийн 704 мэдээллийг байршуулахаас 703 мэдээллийг хуулийн хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроон байршуулж, олон нийтэд тайлагнасан байна.

Мэдээлэл байршуулж байгаа байгууллагын статистик үзүүлэлт:

Хүснэгт 1

д/д	Байгууллагын төрөл	Байгууллагын тоо	Хамаарах хуулийн заалт
1	Гадаадын иргэн, харьяатын газар	1	3.1.
2	ГИХГ-ын боомт, орон нутаг дахь газар, хэлтэс	7	3.1.
Нийт		8	

Гадаадын иргэн, харьяатын газар, боомт, орон нутаг дахь байгууллагын Шилэн дансны нэгдсэн цахим системд мэдээлэл байршуулсан, тайлан илгээсэн байдлын нэгдсэн үзүүлэлт:

Хүснэгт 2

д/д	Байгууллага	Системд бүртгэлтэй байгууллагын тоо	Мэдээлэх давтамжийн тоо	Хугацаандаа мэдээлсэн давтамжийн тоо	Хувь	Тайлан илгээх	Илгээсэн	Хувь	Дундаж хувь
1	ГИХГ	8	704	703	99.8	8	8	100.0	100.0
Нийт		8	704	703	99.8	8	8	100.0	100.0

Хоёр. Байршуулсан мэдээллийн статистик үзүүлэлтийн талаар

Тайлант хугацаанд төсөв гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт, бусад ангиллын мэдээллийг бүтэн жил, хагас жил, сар бүр, тухай бүр гэсэн хугацааны давтамжтайгаар 704 байршуулахаас 703 мэдээллийг хуулийн хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроон байршууллаа.

Байршуулсан мэдээллийг төрлөөр нь ангилан харуулбал:

Хүснэгт 3

Д/д	Байршуулах мэдээллийн төрөл	Нийт мэдээлэх	Мэдээлэл хугацаандаа оруулсан	Хугацаа хоцорсон мэдээлэл	Хэрэгжилт (хувь)
-----	-----------------------------	---------------	-------------------------------	---------------------------	------------------

Нэг. Төсөв гүйцэтгэл (өссөн дүнгээр)					
1	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт - эдийн засгийн ангилал	48	48	-	100.0
2	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хөтөлбөр, зориулалт	48	48	-	100.0
3	Байгууллагын батлагдсан төсөв	8	8	-	100.0
4	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ	48	48	-	100.0
5	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ	48	48	-	100.0
6	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт	48	48	-	100.0
Дүн		248	248	-	100.0
Хоёр. Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт (өссөн дүнгээр)					
7	Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл	48	48	-	100.0
8	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө	8	8	-	100.0
9	Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт	8	8	-	100.0
10	Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл	48	48	-	100.0
11	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг	48	48	-	100.0
Дүн		160	160	-	100.0
Гурав. Бусад (өссөн дүнгээр)					
12	Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт	48	48	-	100.0
13	Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан	8	7	1	87.5
14	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл	48	48	-	100.0
15	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр	48	48	-	100.0
16	Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт	48	48	-	100.0
17	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн	48	48	-	100.0
18	Хавсралт файл	48	48	-	100.0
Дүн		296	295	1	99.8
Нийт дүн		704	703	1	99.8

Системд бүртгэлтэй байгууллагуудын тайлант хугацаанд мэдээлэл илгээх давтамжийг харуулбал:

Шилэн дансны хуульд заасны дагуу тайлант хугацаанд (www.shilendans.gov.mn) нэгдсэн цахим системд Гадаадын иргэн, харьяатын газрын мэдээлэл байршуулах үүрэг бүхий 8 байгууллага 704 мэдээлэл байршуулахаас 703 мэдээллийг хуулийн хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан.

Байгууллагуудыг дэлгэрэнгүйгээр өссөн дүнгээр харуулбал:

Хүснэгт 4

д/д	Байгууллагууд	Системд бүртгэлтэй байгууллагын тоо	Мэдээлэх давтамж	Хугацаандаа	Хугацаа хоцорсон мэдээлэл	Хугацаа болоогүй	Хувь
1	2	3	4	5	5	6	7
1	Гадаадын иргэн, харьяатын газар	1	88	88	-	-	100.0
2	Агаарын замын боомт хариуцсан газар	1	88	88	-	-	100.0
3	Дорноговь аймаг дахь газар	1	88	88	-	-	100.0
4	Хойд бүс дэх газар	1	88	88	-	-	100.0
5	Өмнөд бүс дэх газар	1	88	88	-	-	100.0
6	Баруун бүс дэх газар	1	88	87	1	-	87.5
7	Зүүн бүс дэх газар	1	88	88	-	-	100.0
8	Баян-Өлгий аймаг дахь хэлтэс	1	88	88	-	-	100.0
Нийт дүн		8	704	703	1	-	99.8

Гурав. Дүгнэлт

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа санхүүгийн үйл ажиллагаа болон төсвийн санхүүжилт, зарцуулалтын холбогдох мэдээллийг цахим хуудсанд байгууллагын хэмжээнд 3 ангиллаар 29 төрлийн 704 мэдээлэл байршуулахаас 703 мэдээллийг хуулийн хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроон байршуулж, 99.8 хувийн хэрэгжилттэй “ХАНГАЛТТАЙ” хэмжээнд байна.

Тус байгууллагын дотоод аудит хариуцсан нэгж нь Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд сар бүр хяналт тавьж, мөн “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам” болон хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр төв болон боомт, орон нутаг дахь нэгжүүдтэй хамтран ажиллаж байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
АУДИТЫН ХЭЛТЭС